**ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР**

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

---

“Эрчим хүчний төсөл 2”-ын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

**Аудитын код:** СНАГ-2023/51/НА-СТА-ТХН

---


Цахим хуудас:
www.audit.mn

Улаанбаатар хот
2024 он

Санхүү-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор : Ц.Наранчимэг
Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn

Аудитын менежер: С.Нацагдорж
Утас: 51-260512 Цахим хаяг: natsagdorjs@audit.gov.mn

Ахлах аудитор: Ж.Энхтуяа
Утас: 51-261628 Цахим хаяг: enkhtuyaj@audit.gov.mn

Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: Ди Эй Би Жи Аудит ХХК-ийн захирал Н.Дэлгэрмаа
Утас: 976-91910954 Цахим хаяг: dabg.audit@gmail.com


Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

2024. 02. 23 № 07/343

танай ______________-ны № ______________-т

"ЭРЧИМ ХҮЧНИЙ ТӨСӨЛ 2"-ЫН ЗОХИЦУУЛАГЧ Д.ГАНБААТАР ТАНАА

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу "Эрчим хүчний төсөл 2"-ын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

"Эрчим хүчний төсөл 2"-ын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

"Эрчим хүчний төсөл 2" нь 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдөр хэрэгжиж дуусах байсан ч зээлийн санхүүжилтийн хуваарилагдаагүй үлдсэн 5.6 сая ам.долларыг баруун 6 аймгийн 20 сумын дотоод шугам сүлжээг шинэчлэхэд ашиглахаар Эрчим хүчний яамнаас санал гаргаж Дэлхийн банк зөвшөөрснөөр төслийн үргэлжлэх хугацааг 18 сараар буюу 2024 оны 3 дугаар сарын 31-ний өдөр хүртэл сунгасан.

Дээрх шийдвэрийн дагуу Хэнтий, Ховд, Увс, Баян-Өлгий, Завхан, Говь-Алтай аймгийн 20 суманд 6-15/0.4 кВ-ын түгээх сүлжээг шинэчлэх ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийн үнэлгээний хорооны шийдвэр тайлант оны 10 дугаар сард гарч, цаг агаар хүйтэрсний улмаас барилга угсралтын ажлууд эхлээгүй байна.

**Аудитын гол асуудал**

Барилгын ажлыг дуусгахын тулд төслийн хугацааг дахин 5 сараар буюу 2024 оны 8 дугаар сарын 31-ний өдөр хүртэл сунгахаар Дэлхийн банк, Сангийн яам, Эрчим хүчний яам шийдвэрлэсэн байна. Энэ нь барилгын ажлууд удааширч, төслийн зорилтод үзүүлэлтүүдэд хүрэхгүй байх, гэрээний хугацаанд барилга угсралтын ажил дуусахгүй байх эрсдэлтэй байна.

**Бусад асуудлын хэсэг**

Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 1 зорилтын хүрээнд 3 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 99.2 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.НАРАНЧИМЭГ

## Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

*2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон*

/төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| 1 | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **13,053,955,754.94** | **7,780,554,156.28** |
| 31 | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | **13,053,955,754.94** | **7,780,074,156.28** |
| 312 | **Банкинд байгаа бэлэн мөнгө** | **13,053,955,754.94** | **7,780,074,156.28** |
| 3121 | **Төгрөг** | **3,818,125,794.00** | **496,960,912.79** |
| 31210 | Төрийн сангийн харилцах | 3,818,125,794.00 | 496,960,912.79 |
| 3122 | **Гадаад валют** | **9,235,829,960.94** | **7,283,113,243.49** |
| 31221 | Төрийн сангийн харилцах | 9,235,829,960.94 | 7,283,113,243.49 |
| 33 | **АВЛАГА** | **-** | **480,000.00** |
| 335 | **Бусад авлага** | **-** | **480,000.00** |
| 33510 | Байгууллагаас авах авлага | - | 480,000.00 |
| 2 | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **90,053,916.07** | **46,219,125.49** |
| 392 | **Үндсэн хөрөнгө** | **89,167,552.44** | **46,219,125.49** |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 168,636,364.00 | 168,636,364.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | (117,108,586.09) | (145,214,646.74) |
| 39205 | Машин, тоног төхөөрөмж (компьютер) | 74,893,023.00 | 74,893,023.00 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (44,702,332.33) | (57,184,502.86) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 19,273,597.00 | 19,273,597.00 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (11,824,513.14) | (14,184,708.91) |
| 393 | **Биет бус хөрөнгө** | **886,363.63** | **-** |
| 39301 | Программ хангамж | 5,909,090.90 | 5,909,090.90 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | (5,022,727.27) | (5,909,090.90) |
| 3 | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН** | **13,144,009,671.01** | **7,826,773,281.77** |
| 4 | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **13,144,009,671.01** | **7,826,773,281.77** |
| 51 | **Засгийн газрын хувь оролцоо** | **13,144,009,671.01** | **7,826,773.281.77** |
| 512 | Хуримтлагдсан үр дүн | 13,144,009,671.01 | 7,826,773,281.77 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 10,128,275,880.17 | 13,144,009,671.01 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 3,015,733,790.84 | (5,317,236,389.24) |
| 5 | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН** | **13,144,009,671.01** | **7,826,773,281.77** |

**2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан**

*2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон*

/төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх он | Тайлант он |
|---|---|---|---|
| 1 | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН** | **41,970,018,492.44** | **46,329,728,308.04** |
| 12 | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **41,970,018,492.44** | **46,329,728,308.04** |
| 120 | **Нийтлэг татварын бус орлого** | **41,970,018,492.44** | **46,329,728,308.04** |
| 120044 | Зээлийн санхүүжилт | 33,912,918,728.39 | 21,886,222,984.84 |
| 120009 | Бусад орлого | 750,000.00 | 4,250,000.00 |
| 122004 | Тусламжийн орлого | 8,056,349,764.05 | 24,439,255,323.20 |
| 2 | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **31,421,753,731.14** | **27,200,720,336.36** |
| 21 | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **31,421,753,731.14** | **27,200,720,336.36** |
| 210 | **Бараа, ажил үйлчилгээний зардал** | **31,421,753,731.14** | **27,200,720,336.36** |
| 210101 | Үндсэн цалин | 435,450,000.00 | 433,796,572.00 |
| 210201 | Нийгмийн даатгалын шимтгэлийн зардал | 53,425,410.00 | 53,218,732.00 |
| 2103 | **Байр ашиглалтын тогтмол зардал** | **51,188,556.00** | **51,183,439.00** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 715,263.00 | 1,427,839.00 |
| 210302 | Түлш, халаалт | 607,089.00 | - |
| 210303 | Цэвэр, бохир ус | 616,204.00 | - |
| 210304 | Түрээсийн зардал | 49,250,000.00 | 49,755,600.00 |
| 2104 | **Хангамж, бараа материалын зардал** | **11,337,539.00** | **9,900,034.93** |
| 210401 | Бичиг хэргийн материал | 6,497,383.00 | 6,813,389.00 |
| 210402 | Тээвэр шатахууны зардал | 600,000.00 | - |
| 210402 | Шуудан холбооны зардал | 1,510,156.00 | 1,286,645.93 |
| 210407 | Аж ахуйн материал худалдан авах зардал | 2,730,000.00 | 1,800,000.00 |
| 2106 | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **14,153,364.00** | **25,991,556.00** |
| 210604 | Урсгал засвар | 14,153,364.00 | 25,991,556.00 |
| 2107 | **Томилолт зочны зардал** | **112,484,509.00** | **135,692,671.00** |
| 210702 | Дотоод албан томилолтын зардал | 112,484,509.00 | 135,692,671.00 |
| 2108 | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний зардал** | **21,708,451.50** | **46,486,513.95** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээ | 3,590,728.00 | 29,415,448.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 13,636,364.00 | 16,363,635.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 3,850,830.00 | - |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 190,713.00 | 190,713.00 |
| 210808 | Банкны үйлчилгээний хураамж | 439,816.50 | 516,717.95 |
| 2109 | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **30,722,005,901.64** | **26,444,450,817.48** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 30,677,460,997.32 | 26,400,616,026.48 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал | 44,544,904.32 | 43,834,791.00 |
| 3 | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН** | **10,548,264,761.30** | **19,129,007,971.68** |
| 4 | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГО** | **714,273,338.59** | **221,530,409.48** |
| 145001 | Гадаад валютын ханшийн зөрүүгийн олз | 714,273,338.59 | 221,530,409.48 |
| 5 | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДАЛ** | **8,246,804,309.05** | **24,667,774,770.40** |
| 225001 | Гадаад валютын ханшийн зөрүүгийн гарз | - | 228,519,447.20 |
| 225012 | Хөрөнгө оруулалтаар бэлтгэгдсэн шилжүүлэх зориулалттай хөрөнгийн зардал | 8,246,804,309.05 | 24,439,255,323.20 |
| 6 | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН** | **3,015,733,790.84** | **(5,317,236,389.24)** |

**2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан**

*2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон*

/төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх он | Тайлант он |
|---|---|---|---|
| 1 | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН** | **15,552,970,222.70** | **11,733,869,310.50** |
| 12 | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **15,552,970,222.70** | **11,733,869,310.50** |
| 120 | **Төсөвт байгууллагын өөрийн орлого** | **15,552,970,222.70** | **11,733,869,310.50** |
| 120044 | Зээлийн хөрөнгөөр санхүүжсэн орлого | 15,552,220,222.70 | 11,729,619,310.50 |
| 120009 | Бусад орлого | 750,000.00 | 4,250,000.00 |
| 2 | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **228,902,008.05** | **117,208,696.00** |
| 21 | **Бараа, ажил үйлчилгээний бусад зардал** | **228,902,008.05** | **117,208,696.00** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамж | 228,902,008.05 | 117,208,696.00 |
| 3 | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | **15,324,068,214.65** | **11,616,660,614.50** |
| 22 | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | | |
| 222001 | Тоног төхөөрөмж | 190,454,545.00 | - |
| 4 | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРЛАГЫН ДҮН** | **190,454,545.00** | **-** |
| 5 | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | **(190,454,545.00)** | **-** |
| 6 | **САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| 14 | **Бусад эх үүсвэр** | **714,273,338.59** | **-** |
| 145001 | Гадаад валютын ханшийн зөрүүгийн олз | 714,273,338.59 | - |
| 23 | **Эргэж төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээл** | **12,787,608,313.08** | **16,883,657,390.10** |
| 232001 | Гадаадын төслийн зээлээс санхүүжих зээл | 12,787,608,313.08 | 16,883,657,390.10 |
| 25 | **Санхүүгийн үйл ажиллагааны зардал** | **-** | **6,884,823.06** |
| 250001 | Гадаад валютын ханшийн зөрүүгийн гарз | - | 6,884,823.06 |
| 7 | **САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | **(12,073,334,974.49)** | **(16,890,542,213.16)** |
| 8 | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | **3,060,278,695.16** | **(5,273,881,598.66)** |
| 9 | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | **9,993,677,059.77** | **13,053,955,754.94** |
| 10 | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | **13,053,955,754.94** | **7,780,074,156.28** |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

*2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон*

/төгрөгөөр/

| Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|
| **2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **-** | **10,128,275,880.17** | **10,128,275,880.17** |
| Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | | | |
| **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **-** | **10,128,275,880.17** | **10,128,275,880.17** |
| Тайлант үеийн үр дүн | | 3,015,733,790.84 | 3,015,733,790.84 |
| **2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **-** | **13,144,009,671.01** | **13,144,009,671.01** |
| Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | | | |
| **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **-** | **13,144,009,671.01** | **13,144,009,671.01** |
| Тайлант үеийн үр дүн | | (5,317,236,389.24) | (5,317,236,389.24) |
| **2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **-** | **7,826,773,281.77** | **7,826,773,281.77** |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн гүйцэтгэлийн тайлан

*2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон*

/төгрөгөөр/

| Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|
| **Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн** | **51,945,725,000.00** | **51,612,147,314.38** | **333,577,685.62** | **99.4** |
| **Урсгал зардал** | **151,000,000.00** | **117,208,696.00** | **33,791,304.00** | **77.6** |
| **Бараа, ажил үйлчилгээний зардал** | **151,000,000.00** | **117,208,696.00** | **33,791,304.00** | **77.6** |
| **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **151,000,000.00** | **117,208,696.00** | **33,791,304.00** | 77.6 |
| Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 151,000,000.00 | 117,208,696.00 | 33,791,304.00 | 77.6 |
| **Хөрөнгө оруулалтын зардал** | **24,750,000,000.00** | **24,450,301,250.30** | **299,698,749.70** | 98.8 |
| Их засвар | 24,750,000,000.00 | 24,450,301,250.30 | 299,698,749.70 | 98.8 |
| **Эргэж төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээл** | **27,044,725,000.00** | **27,044,637,368.08** | **87,631.92** | **100.0** |
| Гадаадын төслийн зээлээс санхүүжих зээл | 27,044,725,000.00 | 27,044,637,368.08 | 87,631.92 | 100.0 |
| **Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр** | **51,945,725,000.00** | **46,307,425,777.88** | **5,638,299,222.12** | **89.1** |
| **Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас** | **51,945,725,000.00** | **46,307,425,777.88** | **5,638,299,222.12** | **89.1** |
| Гадаадын эх үүсвэрээс санхүүжих | 27,044,725,000.00 | 21,857,124,527.58 | 5,187,600,472.42 | 80.8 |
| Тусламжийн эх үүсвэрээс санхүүжих | 24,901,000,000.00 | 24,450,301,250.30 | 450,698,749.70 | 98.2 |
| Тохируулсан орлогын дүн | | | | |
| Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | 13,053,955,754.94 | | |
| Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | | 7,780,074,156.28 | | |
| **Байгууллагын тоо** | **1** | **1** | - | |
| **Ажиллагсадын тоо** | **10** | **10** | - | 100.0 |
| Удирдах ажилтан | 1 | 1 | - | 100.0 |
| Гүйцэтгэх ажилтан | 9 | 9 | - | 100.0 |

**Гурав. Аудитын илрүүлэлт:**

Аудитаар нийт 3,579.0 мянган төгрөгийн 1 алдаа[1] илэрснийг аудитын явцад залруулсан.

*Залруулсан алдаа:*

- Тайлант оны элэгдлийн зардлыг 3,579.0 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан нь УСНББОУС 17.66 "Элэгдэл гэдэг нь хөрөнгийн элэгдүүлэх дүнг түүний ашиглалтын хугацааны туршид хуваарилах системтэй хуваарилалт юм" гэсэн заалтай нийцээгүй, тохиолдсон байх батламж мэдэгдлийг хангаагүй;

Аудитаар нийт 11,533.6 мянган төгрөгийн 3 зөрчил[2] илэрснээс Төслийн үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилт хангалтгүй, удаашралтай байгаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх албан шаардлага 1, жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг хуулийн хугацаанд аудитад ирүүлээгүй зөрчилд хариуцлага тооцуулах албан шаардлага 1 тус тус хүргүүлж, 11,533.6 мянган төгрөгийн зөрчилд 1 зөвлөмж өгсөн.

**Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

| Дд | Алдааны товч утга | Нийт алдаа | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс: | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| 1 | Тайлант оны элэгдлийн зардлыг 3,579.0 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан. | 1 | 3,579.0 | 1 | 3,579.0 | 1 | 3,579.0 | | |
| **Дүн** | | **1** | **3,579.0** | **1** | **3,759.0** | **1** | **3,579.0** | **-** | **-** |

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

| Дд | Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс: | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо |
| 1 | Төслийн санхүүгийн ажилтан солигдож шинэ ажилтан 2023 оны 12 дугаар сарын 26-нд томилогдсон, завсрын аудитад баримт материал ирүүлээгүй. Төсөл хэрэгжүүлэгч нэгж нь 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тйалан, төсвийн гүйцэтгэлийг аудит хийлгэхээр хуулийн хугацааг 5 өдөр хоцроож 2024 оны 2 дугаар сарын 01-ний өдөр ирүүлсэн. | 1 | - | | | | | 1 | 1 |
| 2 | Төслийн удирдах хорооны зөвлөмжийн дагуу тайлант онд хэрэгжиж дуусах байсан нийт 87,083,350.0 мянган төгрөгийн 14 худалдан авалтын гэрээний хугацааг сунгасан байна. “Эрчим хүчний төсөл 2” нь 2017 оны 12 дугаар сарын 15-наас | 1 | - | 1 | - | | | | |

[1] Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

[2] Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 2022 оны 09 дүгээр сарын 30-ны хооронд хэрэгжих дуусах байсан ч барилгын ажил гүйцэтгэх гэрээнүүд хугацаандаа дуусдаггүй, жил бүр гэрээний хугацааг сунгадаг нь төслийн хэрэгжих хугацааг 2024 оны 03 дугаар сарын 31-ний өдөр хүртэл 18 сараар сунгасанд нөлөөлж байна. Төслийн хугацаа сунгаснаар валютын ханшийн алдагдалд орох, төсөл хэрэгжүүлэх нэгжийн зардал өсөх, өмнө гүйцэтгэсэн ажлын чанарт нөлөөлөх, төсөл үр дүнтэй хэрэгжихгүй байх зэрэг эрсдэлтэй байна. | | | | | | | | |
| 3 | Төслийн тайлант оны үйл ажиллагааны зардлыг анхан шатны баримттай тулгахад 11,553.6 мянган төгрөгийн и-баримтгүй байрны түрээс, ашиглалтын зардал тайлагнасан байна. | 1 | 11,533.6 | | | 1 | 11,533.6 | | |
| **Дүн** | | **3** | **11,533.6** | **1** | **-** | **1** | **11,533.6** | **1** | **1** |

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитаар Шилэн дансны тухай хуулийн дагуу мэдээллийг тогтоосон хугацаанд иж бүрэн байршуулаагүй 7,785,815.0 мянган төгрөгийн зөрчилд зөвлөмж хүргүүлэв.

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс: | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Шилэн дансны цахим хуудсанд байршуулах ёстой нийт 156 мэдээнээс 154 мэдээг хугацаанд нь оруулсан. Үүнээс Дараа жилийн төсвийн төсөл, Аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан, Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарын нийт 7,785,815.0 мянган төгрөгийн 4 мэдээ хугацаа хоцроосон. | 1 | 7,785,815.0 | | | 1 | 7,785,815.0 |
| **Дүн** | **1** | **7,785,815.0** | **-** | **-** | **1** | **7,785,815.0** |